



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/416

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 4.2.5, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн А/285 дугаар захирамжийн хавсралтын 13 дахь мөрөнд “Арга хэмжээний нэр” гэсэн хэсгийн “Урандөш хүүхдийн зуслангийн гүүрний засварын ажлын зураг төсөл боловсруулах”, “Төсөвт өртөг” нь “2,500,000”- гэснийг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр засварлах боломжгүй нь тогтоогдсон, мөн холбогдох байгууллагын саналыг үндэслэн “Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын чигжийн голын гүүр барих ажлын зураг төсөл боловсруулах даалгавар”, “Төсөвт өртөг” нь “5,000,000” гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх өөрчлөлт орсон төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

6712011396